

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫГ ТОМИЛОХ ТУХАЙ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2014 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан Ардчилсан Нам Улсын Их Хуралд суудалтай бусад нам, эвсэлтэй зөвшүүлцэн Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар нэр дэвшиүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай саналыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Нэргүй танилцуулав.

Чимэдийн Сайханбилэг нь 1991-2003 онд Монголын залуучуудын холбоонд ажилтан, нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгч, 1996-2000 онд Улсын Их Хурлын гишүүн, 1998-1999 онд Гэгээрлийн сайд, 2004-2008 онд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга, 2008-2012 онд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, 2012 оноос Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар тус тус ажиллаж байгаа бөгөөд төрийн болон улс төрийн албанад 22 жил ажилласан, бэлтгэгдсэн, мэргэшсэн, чадвартай шилдэг боловсон хүчин болох талаар дээрх танилцуулгад дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг Ерөнхий сайдаар томилогдсон тохиолдолд Засгийн газрыг хэрхэн бүрдүүлэх, түүнчлэн өмнөх Засгийн газрын эдийн засгийн бодлогыг үргэлжлүүлэх, өөрчлөлт оруулах эсэх, ажлаа хэрхэн төлөвлөх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл эдийн засаг хүнд байгаа энэ үед Ерөнхий сайдаар томилогдвол инфляцийн эсрэг дунд хугацааны хөтөлбөр гаргаж, үнийн өсөлтийг хязгаарлах, 2015 онд татварын өршөөлийг эдийн засгийн ил тод байдалтай хослуулан хэрэгжүүлэх, Монгол Улсын гадаад нөхцөл байдлыг сайжруулах, зээлийн удирдлага, өрийн эргэн төлөлтийн асуудлаар иж бүрэн төлөвлөгөө гаргах зэрэг үндсэн асуудлыг анхаарч ажиллахыг; Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд тогтвортой ажиллах Засгийн газрыг эхнээсээ бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийн сааралтыг тогтвожуулах, санхүүгийн эрсдлээс сэргийлж, санхүүжилтийн олон эх үүсвэр бүхий менежментын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авах, энэ хүрээнд төсвийн тодотгол хийх, зээлийн удирдлагыг сайжруулахад анхаарах нь зүйтэй зэрэг саналыг нэр дэвшигчид хандан илэрхийлэв.


Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай асуудлаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ